



2019 оны үйл ажиллагааны ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

Баянхонгор аймаг
Цусны салбар төв

ДОНОРЫН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА:

Донорын эгнээг өргөжүүлэх, доноруудыг идэвхжүүлэх, алдаршуулах, донор сурталчлах, сургалт сурталчилгааны ажлыг аймгийн ЭМГ, УЗХороотой хамтран нийт ард иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна. Баянхонгор аймагт байрлах Зэвсэгт хүчний 339-р цэргийн анги, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Говь-Алтай аймаг дахь АШУҮИС-ийн оюутнууд, АЗДТГ-тай хамтран “Сэтгэлийн дуудлага”, “Амьдрал бэлэглэе” нэртэй аяныг зохион байгуулж, өөрийн нөөц бололцоонд тулгуурлан сургалт сурталчилгааны гарын авлага боловсруулах, ЦССҮТ-өөс гарын авлага, сургалт сурталчилгааны материалыг татан авч иргэд, байгууллагуудад түгээх ажлыг зохион байгуулсан.

ДОНОРЫН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА:

Нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албатай хамтран Үндэсний цус бэлэглэх өдөр буюу сар бүрийн 3-нд тасаг нэгжийн оролцоотойгоор хуваарийн дагуу байгууллагуудад сургалт хийж байна. Сар бүр сургалт сурталчилгааг хийснээр донорын эгнээнд байгууллага хамт олноороо нэгдэж цусаа бэлэглэж байна.




ДОНОРЫН ЭМЧИЙН ҮЗЛЭГ:

Донор сонгох шалгуур үзүүлэлтийг баримтлан доноруудыг сонгон, эмчийн үзлэг асуумжид хамруулж байна. Эмчийн асуумж үзлэгээр нийт 25 донор хасагдсанаас, донорын насны хязгаар, эрүүл мэндийн байдал зэргээс шалтгаалан бүрмөсөн хасагдсан донор 18, халдварын голомттой улс оронд зорчсон-1, дархлаажуулалт хийлгэсэн-3, антибиотик эмчилгээ хийлгэсэн-1, хөхүүл эмэгтэй-2 гэсэн шалтгаанаар 7 донор түр хугацаагаар хасагдаж, үзлэг асуумжаар хасагдалт 3,6%-тай байна.

ЦУС ЦУГЛУУЛАЛТ:

Цусны салбар төв нь суурин хэлбэрээр 79,8 литр буюу 214 нэгж, 3 удаагийн явуулын хэлбэрээр нийт 11,8 литр буюу 34 нэгж нийт 91,6 литр буюу 248 нэгж цус цуглуулсан байна.

ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН ЦУГЛУУЛСАН ХЭЛБЭР, НЭГЖ ТОО




ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

- * Тухайн онд 248 нэгж бүхэл цус цуглуулж, шинжилгээгээр 8 нэгж цус хасагдаж нийт 240 нэгж цус үйлдвэрт тэнцсэн байна.


Үйлдвэрт тэнцсэн цуснаас:

- * Даршилсан улаан эс 227 нэгж
- * Хөлдөөсөн шинэ сийвэн 191 нэгж
- * ЦЭУЭӨтгөрүүлэг 5 нэгж
- * ЦЭДУЭс 3 нэгж
- * Угаасан улаан эс 4 нэгж
- * Улаан эсийн өтгөрүүлэг 8 нэгж
- * Криоприцепитат 45 нэгж
- * К сийвэн 45 нэгж
- * Ялтаст эсийн өтгөрүүлэг 23 нэгжийг үйлдвэрлэж нийт 551 нэгж ЦЦБ үйлдвэрлэсэн.


Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл



ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ



ЭМНЭЛЭГТ ОЛГОСОН ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ



ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭЛТ:

Сумдын ЭМТ-ийн эмчилгээнд:

- * Баянговь, Баацагаан, Баянцагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Галуут, Бөмбөгөр, Баян-Өндөр сумдын ЭМТ-дэд нийт 23 нэгж хөлдөөсөн шинэ сийвэн тээвэрлэж сэлбэлт хийгдсэн ба тээвэрлэлтийн үеийн горим алдагдаагүй.

ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УСТГАЛ, АКТ:

- * Шинжилгээний хариу эерэг гарч устгалд орсон цус 10 нэгж
- * Хугацаа дуусч актлагдсан
 - Улаан эсийн бүтээгдэхүүн 23 нэгж
 - Сийвэнгийн бүтээгдэхүүн 10 нэгж

ЦУГЛУУЛСАН ЦУСНЫ НЭГЖ БҮРТ ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ:


Цуглуулсан цусны нэгж бүрт ЦСДХ илрүүлэх шинжилгээг 248 донорт хийж, 8 донорын шинжилгээ эерэг гарч шинжилгээгээр хасагдалт 3,2%-тай байна.

Шинжилгээгээр:

- * HCV-2
- * HBsAg-2
- * TRNA-4 илэрсэн.

Шинжилгээгээр эргэлзээтэй гарсан сорьцыг ЦССҮТ-ийн лавлагаа лабораторит илгээж баталгаажуулсан.

ЦСДХ ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭГЭЭР ДОНОР ХАСАГДАЛТ



СУВИЛАГЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ:


- “ЦЦБ-ний аюулгүй байдал, цусны бүлэг тодорхойлох арга зүй” сэдвээр 37 сувилагч, тусгай мэргэжилтэнд
- “Цусны бүлэг тодорхойлох аргачлал, биологийн тохироо тодорхойлох” сэдвээр 54 сувилагч, тусгай мэргэжилтэнд
- “Цусны бүлэг тодорхойлох арга зүй” сэдвээр дадлага сургалтыг Дотор, ЭЭМГД-ын тасгийн 26 эмч, сувилагч тусгай мэргэжилтэнд

ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ:

- “Цусны аюулгүй байдал, өвчтөний танин тодруулга” сэдвээр 98 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тэнхимийн болон дадлага сургалтыг зохион байгуулсан.

СУМДЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ:

- “ЦЦБ-ний эмнэлзүйн зохистой хэрэглээ, аюулгүй цус сэлбэлт”, “Цусны бүлэг тодорхойлох аргачлал, ЦЦБ-ний тээвэрлэлт, хүйтэн хэлхээний горим”, “Цусны хүүдийг ашиглах аргачлал” сэдвүүдээр сумдын ЭМТ-ийн 8 эмч, 6 эх баригчид ажлын байрны дадлага сургалтуудыг хийсэн.





**Анхааралд хандуулсанд
баярлалаа**